



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/438

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн Монгол Улсад мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчны нөхөн сэргээлт, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны тоолууржуулалт, бүх төрлийн татвар, төлбөр, хураамжийн ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж заавар, зөвлөгөө өгөх ажлын хэсгийн томилолт,шатахууны зардалд 3,825,840 (гурван сая найман зуун хорин таван мянга найман зуун дөчин) төгрөгийг зарцуулсугай.

2.Томилолтын зардлын тооцоог нэгдүгээр хавсралтаар, шатахууны зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлт зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Ажис

Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 02-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа
Аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтаар ажиллах ажлын хэсгийн томилолтын тооцоо

№	Сумдууд	Нэрс	Хоног	Нэг өдөрт ногдох	Дүн
1	Баруун	А.Гантөмөр	3	64,000	192,000
2		Б.Эрийнтовч	3	64,000	192,000
3		П.Батгэрэл	3	64,000	192,000
		Дүн			576,000
1	Хойд	А.Гантөмөр	3	64,000	192,000
2		Б.Эрийнтовч	3	64,000	192,000
3		П.Батгэрэл	3	64,000	192,000
		Дүн			576,000
1	Зүүн	А.Гантөмөр	3	64,000	192,000
2		Б.Эрийнтовч	3	64,000	192,000
3		П.Батгэрэл	3	64,000	192,000
		Дүн			576,000
1	Урд	А.Гантөмөр	3	64,000	192,000
2		Б.Эрийнтовч	3	64,000	192,000
3		П.Батгэрэл	3	64,000	192,000
		Дүн			576,000
		Нийт дүн			2,304,000

Аймгийн Засаг даргын 2022
 оны 05 дугаар сарын 02-ны
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа
 Аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтаар явах машинуудын шатахууны тооцоо

№	Чиглэл	Шатахууны төрөл	Шатахууны нэг бүрийн үнэ	Норм (100 км-т)	Нийт явах км	Шатахууны хэмжээ	Нийт дүн (төг)
1	Урд сумд	ДТ	3730	20	460	92	343,160
2	Баруун сумд	ДТ	3730	20	390	78	290,940
3	Зүүн сумд	ДТ	3730	20	620	124	462,520
4	Хойд сумд	ДТ	3730	20	570	114	425,220
	Нийт дүн				2040	408	1,521,840